

МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ  
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ



ГАНЗАМ СОНИН ХЭВЛҮҮЛЭХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Ганзам Сонин Хэвлүүлэх

Төслийн дугаар: УБТЗ /2020/ХА1Б/104

Улаанбаатар хот



## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020-09-02

Тендер шалгаруулалтын нэр: **Ганзам Сонин Хэвлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **УБТЗ/2020/ХА/Б/104**

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “**Ганзам Сонин хэвлүүлэх**” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү худалдан авах ажиллагаа нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерээ илгээхийн өмнө **50,000 /тавин мянган/ төгрөгийг** цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **2020 оны 09-р сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө** [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар цахим системээр ирүүлж **2020 оны 9-р сарын 11-ний өдрийн 10 цаг 30 минут-т** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж - 42,  
УБТЗ-ын удирдах газар, 287 тоот  
Утас: 21-242175, Факс: 976-21-242178  
Имэйл хаяг: nh@ubtz.mn  
Веб хаяг: www.ubtz.mn**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлгэдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойполт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p><b>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:</b> Сүүлийн 1 жилийн /2019 он/ санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.</p> <p><b>Борлуулалтын хэмжээ:</b> 2019 оны борлуулалтын орлого нь нийлүүлэхээр санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.</p> <p><b>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</b> 2019 оны ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, актын хамт ирүүлнэ.</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу тендер нээсэн өдрөөр цахим системтэй холбогдсон мэдээллийн баазаас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана. Тендерт оролцогч тендер нээх өдрийн байдлаар татварын өргүй байх шаардлагатай;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг тендер зарласан өдрөөс хойш нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>- НӨАТ-ын гэрчилгээний хуулбарыг тендер зарласан өдрөөс хойш нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>- Захирлын эсхүл гэрээнд гарын үсэг зурах итгэмжлэгдсэн эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг тендер зарласан өдрөөс хойш нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>- Байгууллагын тухай дэлгэрэнгүй танилцуулга ирүүлнэ.</li> <li>- ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтын эх хувийг ирүүлнэ.</li> <li>- Сүүлийн 3 жилийн хугацаанд гэрээний үүргээ зөрчсөн эсэх талаара шүүхийн төрөлжсөн архивын лавлагааг ирүүлнэ.</li> <li>- Харилцагч бүх банкны хугацаа хэтэрсэн зээл болон хугацаа хэтэрсэн хүүгийн өр төлбөргүй тухай тодорхойлолтыг ирүүлнэ.</li> <li>- Техникийн тодорхойлолтод байгаа үзүүлэлтийг санал болгож байгаа барааны үзүүлэлттэй харьцуулан ирүүлнэ.</li> <li>- Техникийн шаардлагыг хангагүй тохиолдолд 7 хоногийн дотор үнэ төлбөргүй дахин хэвлэж өгөхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Санал болгож буй барааг санал болгож буй үнээрээ хугацаандаа нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</li> </ul>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайт руу <b>2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минутаас</b> өмнө илгээсэн байна.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-42, “УБТЗ”-ын Удирдах газар, Худалдан авалт, борлуулалтын алба.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 дугаар давхар 287 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b>.</p> <p><b>Төсөвт өртөг: 49,140,000 төгрөг</b></p>

### Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

#### 1. Барааны тодорхойлолт:

Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолт нь дараах стандарт шаардлагад нийцсэн байна.

Дд	Бараа болон холбогдох бусад үйлчилгээний нэр	Формат	Өнгө	Нүүрний тоо	Үзүүлэлт	7 хоног тутам хэвлэгдэх тоо	Нийт тоо хэмжээ
1	Ганзам Сонин	A2	4+1*2	8	65гр Сонины цаас. 4-н нүүр нь өнгөт, 4-н нүүр нь хар.	5,400 ширхэг	189,000 ширхэг

#### 2. Баглаа, боодол: Баглаа боодолтой байна.

#### 3. Бараа хүргэх газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Замчны гудамж-1, УБТЗ-ын Ган Зам Пресс төв

**4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:****БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермсийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Ганзам сонин	Формат: А2; Өнгө: 4+1*2; Нүүр: 8; 65гр Сонины цаас; 4-н нүүр нь өнгөт; 4-н нүүр нь хар;	189,000	ширхэг	УБТЗ-ын Ган Зам Пресс төв	Гэрээ байгуулснаас хойш <b>7 хоног бүрийн Мягмар гаригийн өглөө 6 цагт хүлээн авна.</b>		

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэ г	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>	<p><b>1.1. Захиалагч тал барааг шалгаж, хүлээн авна. 2 тал барааг хүлээн авсан акт үйлдэн хүлээлцэнэ.</b></p>
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>	<p><b>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li> <li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> <li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li> <li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li> </ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p>
<b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>	<p><b>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</b></p>
<b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>	<p><b>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</b></p> <p>Урьдчилгаа төлбөр олгохгүй, бөгөөд нийлүүлэгч барааг 100% бүрэн хүлээлгэж өгсөний дараа төлбөрийн нэхэмжлэх, зарлагын баримт, хүлээлцсан акт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч төлбөрийг төлнө.</p>
<b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>	<p><b>9.1. Алданги оногдуулах хувь: <b>0.05 хувь</b></b></p> <p>Алдангийн нийт дүн: <b>10 хувиас хэтрэхгүй</b></p>

## Долоо. ДОЛДУГААР БҮЛЭГ

### ГЭРЭЭНИЙ МАЯГТ

УБТЗ-ын даргын 2018 оны ...дугаар сарын ....ны  
өдрийн ...тоот тушаалын ..... хавсралт

### ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

201..... оны ..... дугаар  
сарын ....-ний өдөр  
хот

№

Улаанбаатар

Энэхүү худалдах, худалдан авах гэрээ /Цаашид “Гэрээ” гэх/-г  
Нэг талаас: Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг  
/итгэмжлэлээр хийж байгаа бол түүнийгээ бичнэ/ түүнийг төлөөлж .....  
(цаашид “Худалдан авагч” гэх),

Нэгөө талаас: Улсын бүртгэлийн ..... Регистрийн ..... дугаартай  
....., түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал албан тушаалтай ..... (цаашид  
“Худалдагч” гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол улсын  
Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан  
тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл,  
заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн  
илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1 Гэрээний зорилго:

1.1.1. Худалдагч нь стандартын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан  
биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй бараа бүтээгдэхүүн, түүнтэй  
холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх,  
худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог  
гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

#### 1.2 Гэрээний хавсралтууд:

Дараах бичиг баримтуудыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний  
салшгүй хэсэг болно. Үнд:

1.2.1 Худалдан авах бараа бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт / Хавсралт  
1/

1.2.2 Бараа бүтээгдэхүүний жагсаалт, нийлүүлэх хуваарь /Хавсралт 2/

1.2.3 Бараа бүтээгдэхүүний нэгжийн болон нийт үнэ /Хавсралт 3/

1.2.4 Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ /Хавсралт 4/

1.2.5. Нийлүүлэх бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, стандартын шаардлага  
хангасныг гэрчлэх үйлдвэрлэгчийн болон мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт  
/Хавсралт 5/

1.2.6 Үйлдвэрлэгчийн болон нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ  
/Хавсралт 6/

1.2.7 Үйлдвэрлэгчийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт, туршилтын гэрчилгээ  
/Хавсралт 7/

1.2.8 Бараа бүтээгдэхүүнд шаардлагатай дагалдах бичиг баримтууд /ашиглалтын  
заавар г.м/ /Хавсралт 8/

1.2.9 Бусад /тухайн худалдан авах бараа бүтээгдэхүүнээс шалтгаалан бусад  
хавсралтуудыг нэмж болно. Ж:зураг төсөл, төсөв г.м/ /Хавсралт 9/

1.3 Гэрээний 1.2-т заасан Хавсралт 4,5,6,7,8-д заасан баримт бичгийг бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхээс 5 хоногийн өмнө Худалдан авагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд Худалдан авагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг Худалдагч өөрөө хариуцна.

### **Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл**

#### **2.1 Гэрээний үнэ:**

2.1.1 Бараа бүтээгдэхүүний нийт үнэ: ..... /...../ үнийг заавал тоо болон үсгээр бичсэн байна/.

2.1.2 Гэрээний үнийн задаргааг Хавсралт 3-д заасан болно. Уг үнэд гаалийн болон НӨАТ, тээврийн болон бусад зардлууд бүрэн орсон болно. /Хэрэв НӨАТ төлөгч биш бол харьяа татварын албанаас НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй гэсэн тодорхойлолт авсан байх шаардлагатай бөгөөд энэ талаар гэрээнд дурдана./

2.1.3 Гэрээний хэрэгжилтийн явцад шинээр батлагдсан хууль, төрийн аливаа шийдвэрүүдэд нэмэлт болон өөрчлөлт орсон нь гэрээний үнэд өөрчлөлт орох үндэслэл болохгүй.

2.1.4 Гэрээний үнэ гэрээний хүчинтэй хугацаанд тогтмол байна.

#### **2.2. Гэрээний үнийг төлөх нөхцөл**

2.2.1 Гэрээ хэрэгжихээс өмнө ямар нэг урьдчилгаа төлбөрийг Худалдан авагч, Худалдагчид төлөхгүй.

2.2.2 Гэрээний Хавсралт 1-д заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан Гэрээний хавсралт 2-т заасан жагсаалт болон хуваарийн дагуу бараа бүтээгдэхүүнийг талууд харилцан акт үйлдэн албан ёсоор хүлээж авсны дараа, бараа бүтээгдэхүүний үнэ болох ..... (.....) төгрөгийг Худалдагчийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Худалдагчийн ..... тоот дансанд шилжүүлнэ.

2.2.3 Гэрээний 2.1.1-д заасан бараа бүтээгдэхүүн худалдан авах нийт үнийн дүнгийн 5 хувийг гэрээний .....-д заасан баталгаат хугацаа дуусах хүртэл барьцаа болгон авч үлдэнэ.

2.2.4 Худалдан авагч тал гэрээнд заасан үнийг хугацаанд нь шилжүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ..... хувиар алданги гүйцэтгэгч талд төлнө.

#### **Гурав. Гэрээний хугацаа, бараа бүтээгдэхүүний доголдол, хүлээн авах, өмчлөх, сав баглаа боодол**

##### **3.1 Гэрээний хугацаа**

3.1.1 Бараа бүтээгдэхүүнийг гэрээний Хавсралт 2-т заасан хугацааны дотор Худалдагч нь Худалдан авагчид бүрэн хэмжээгээр хүлээлгэн өгнө.

3.1.2 Худалдагч тал бараа, бүтээгдэхүүнийг Гэрээний хавсралт 2-т заасан хугацаанд Худалдан авагчид нийлүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ..... хувиар алданги тооцон Худалдан авагчид төлнө.

3.1.3 Бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх хугацаанд байгалийн гэнэтийн үзэгдэл болон гамшгаас үүдэн гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдагч Худалдан авагчид урьдчилан бичгээр мэдэгдэж нийлүүлэх хугацааг тохиролцох эсвэл гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авна.

3.1.4 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний дагуу урьдчилгаа төлбөрийг Худалдан авагч талын анхны шаардлагаар саадгүй төлнө. /Гэрээний дагуу урьдчилгаа төлбөр төлсөн тохиолдолд энэ заалт үйлчилнэ/

3.1.5. Энэхүү гэрээ нь ...../гэрээний үйлчлэх хугацааг бичнэ/ хүртэл хугацаанд үйлчилнэ.

##### **3.2 Баталгаат хугацаа**

3.2.1 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгснөөс хойш ..... баталгаат хугацаа өгч байгаа болно.

##### **3.3 Бараа бүтээгдэхүүний доголдол**

3.3.1 Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш болон баталгаат хугацаанд худалдан авсан бараа бүтээгдэхүүнд үйлдвэрийн доголдол илэрвэл Худалдагч нь ажлын ..... хоногийн дотор доголдлыг газар дээр нь арилгах буюу ижил төрлийн өөр шинэ бараа бүтээгдэхүүнээр шууд сольж өгнө.

3.3.2 Доголдлыг арилгаснаас хойш .... сарын дотор засварласан болон сольсон бараа, бүтээгдэхүүнд энэ төрлийн болон бусад гэмтэл согог, доголдол дахин гарсан тухай Худалдан авагчаас бичгээр мэдэгдэл ирвэл уг доголдлыг Худалдагч үнэ төлбөргүй шуурхай арилгана.

3.3.3 Хэрэв хугацаа хэтэрвэл уг барааны анхны үнийн дүнгийн ..... хувиар алданги тооцон Худалдан авагчид төлнө. Доголдлыг арилгахтай холбоотой гарсан зардлыг Худалдагч тал бүрэн хариуцна.

3.3.4 Түүнчлэн доголдол гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол Худалдагч өөрөө Худалдан авагчийн 2.2.3-т барьцаа болгон тавьсан төлбөрөөс тооцон уг доголдлыг арилгана.

#### **3.4 Бараа, бүтээгдэхүүн хүлээн авах, хүлээлгэн өгөх**

3.4.1 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг Хавсралт 2-т заасан жагсаалтын дагуу нийлуулж ба уг хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

3.4.2 Худалдагч бараа бүтээгдэхүүнийг хавсралтад заасан газар өөрийн зардлаар үнэ төлбөргүй хүргэж, угсарч суурилуулж өгнө.

3.4.3 Талууд бараа бүтээгдэхүүнийг акт үйлдэн хүлээн авч, хүлээлгэн өгнө. Энэхүү хүлээн авсан, хүлээлгэн өгсөн акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

3.4.4 Бараа, бүтээгдэхүүн хүлээлцсэн актад талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурснаар бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсанд тооцно.

#### **3.5 Өмчлөх эрх**

3.5.1 Энэхүү гэрээний 3.4.3, 2.2.2-д тус тус заасны дагуу бараа бүтээгдэхүүнийг актаар хүлээн авч, төлбөрийг бүрэн төлснөөр тухайн бараа бүтээгдэхүүний өмчлөх эрх /оюуны өмчийн эрх мөн нэгэн адил/ Худалдан авагчид бүрэн шилжинэ.

3.5.2 Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх нь Улсын бүртгэлд бүртгүүлснээр шинэ өмчлөгчид шилжинэ. Өмчлөх эрх шилжихтэй холбоотой аливаа зардлыг төлөх асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.5.3 Бараа бүтээгдэхүүн эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг Худалдагч болон Худалдан авагч зөрчсөн хэмээн гуравдагч этгээд нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг Худалдагч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.

#### **3.6 Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, хадгалалт**

3.6.1 Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана.

3.6.2 Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна.

3.6.3 Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.

3.6.4 Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний Хавсралт 1-д заасан шаардлага болон Худалдан авагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

#### **3.7 Бараа бүтээгдэхүүний стандарт шаардлага**

3.7.1 Худалдагч нь энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолтод нийцсэн байна

3.7.2 Худалдан авагч нь гэрээнд холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ.

### **Дөрөв. Талуудын эрх, үүрэг**

#### **4.1 Худалдагчийн хариуцлага, эрх, үүрэг**

4.1.1 Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан үзүүлэлтийн дагуу заагдсан хугацаанд, холбогдох баримт бичгийн хамт шилжүүлэх,

4.1.2 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг ашиглах дэлгэрэнгүй заавар зөвлөмжийг Монгол хэл дээр бэлтгэж хүлээлгэн өгөх ба шаардлагатай бол үнэ төлбөргүй сургалт зохион байгуулах,

4.1.3 Бараа бүтээгдэхүүний Худалдан авагчид хүлээлгэн өгөх хүртэл зориулалт, хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, бүрэн бүтэн байдал, эрсдэлийг хариуцах,

4.1.4 Бараа бүтээгдэхүүний талаар үнэн зөв, бүрэн мэдээллийг өгөх,

4.1.5 Худалдан авагчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн болон түүний аюулгүй ажиллагааны талаар олж авсан мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх,

4.1.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлээгүйгээс нөгөө талдаа учруулсан хохирлыг нөхөн төлөх,

4.1.7 Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэхдээ гэрээний Хавсралт 2-т заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг хатуу мөрдөх,

4.1.8 Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх,

4.1.9 Гэрээний үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг Худалдан авагчаас шаардах,

#### **4.2 Худалдан авагчийн хариуцлага, эрх, үүрэг**

4.2.1 Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах,

4.2.2 Бараа бүтээгдэхүүнд үйлдвэрийн доголдол илэрвэл доголдлыг арилгуулах, ижил төрлийн бараагаар солиулах, доголдлыг арилгахад гарсан зардлаа төлүүлэх,

4.2.3 Худалдан авагч нь барааг захиалснаас хойш Худалдагчтай зөвшилцэн барааны нэр төрөл, маркийг солих, өөрчлөх болон захиалгаа цуцлах,

4.2.4 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор Худалдан авагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх,

4.2.5 Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Худалдан авагч нь тус бараанаас татгалзах эрхтэй ба Худалдагч нь тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээг авах,

4.2.6 Барааг тээвэрлэхээс өмнө Худалдан авагч эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох Худалдан авагчийн эрхийг хөндөхгүй,

4.2.7 Гэрээний 4.2.6-д заасан Худалдан авагч нь шалгаж, туршсан аль ч нөхцөл, болзол нь Худалдагчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй,

4.2.8 Бараа бүтээгдэхүүний үнийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх,

4.2.9 Бараа бүтээгдэхүүнийг акт үйлдэн хүлээн авах,

### **Тав. Бусад зүйл**

#### **5.1 Гэрээ цуцлах**

5.1.1 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах бол талууд бие биедээ ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5.1.2 Дараах тохиолдолд гэрээг Худалдан авагч өөрийн санаачилгаар цуцална.

Үүнд:

а/Бараа бүтээгдэхүүн нь гэрээнд заасан чанарын шаардлага, бусад үзүүлэлтийг хангаагүй.

б/Бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид шилжүүлээгүй.

### **5.2. Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах**

5.2.1 Худалдан авагч Худалдагчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний Хавсралт 2-т заасан цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчилж болно. Үүнд:

а/Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүнийг Худалдан авагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

б/Тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

в/бараа, бүтээгдэхүүнийг хүргэх газар.

### **5.3 Баталгаа**

5.3.1 Бараа бүтээгдэхүүн нь хамтран өмчлөгчүй, ямар нэг төлбөрийн барьцаанд байхгүй болно гэдгийг Худалдагч тал баталгаа гаргаж байгаа болно.

5.3.2 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг Гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

5.3.3 Талууд энэ гэрээнд дурдсан өөрийн эрхийг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гурав дахь этгээдэд шилжүүлэн өгч болохгүй.

### **5.4 Маргаан шийдвэрлэх**

5.4.1 Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.

5.4.2 Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.4.3 Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **5.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

5.5.1 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай санаалаа нэг тал нөгөө талдаа харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

5.5.2 Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

5.5.3 Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

### **5.6 Нууцыг хадгалах**

5.6.1 Худалдан авагч талаас өгсөн аливаа нэг мэдээллийн нууцыг гэрээний хугацаа дууссан эсэхээс үл хамааран чанд хадгална.

5.6.2 Худалдагч нь Худалдан авагчийн зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, too мэдээлэл, олж авсан болон цуглувулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.

5.6.3 Нууц хадгалах үүргээ биелүүлэхгүйгээс Худалдан авагчид ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна.

### **5.7 Давагдашгүй хүчин зүйл**

5.7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг, дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдал бий болохыг ойлгоно.

5.7.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын таван хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хуанлийн 30-аас дээш хоногийн хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

5.7.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд харилцан чөлөөлөгднө.

5.7.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэнийг эрх бүхий байгууллага /MYXAYT/ нотолсон байвал зохино.

### **5.8 Гэрээ хүчин төгөлдөр болох**

5.8.1 Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр ..... эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.8.2 Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захицууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

5.8.3 Энэхүү гэрээний 1.2-т заасан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ.

5.8.4 Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

Худалдагч:

Хаяг:

Утас:

Э-майл :

Холбогдох /харьцах/ албан тушаалтан:

Худалдан авагч:

Хаяг:

Утас:

Э-майл :

Холбогдох /харьцах/ албан тушаалтан:

**ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.**

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

..... / .....

**ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

..... / .....

Худалдах, худалдан авах гэрээний

Хавсралт 1

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

5. Бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт:
6. Стандарт, шаардлага:
7. Баглаа, боодол:
8. Бараа, бүтээгдэхүүн хүргэх эцсийн газар:
9. Бусад

Хүлээн зөвшөөрсөн :

Худалдагчийг Төлөөлж:

..... / ..... /

Худалдан авагчийг төлөөлж:

..... / ..... /

Худалдах, худалдан авах гэрээний

Хавсралт 2

**Бараа бүтээгдэхүүний жагсаалт, нийлүүлэх хуваарь**

№	Бараа, бүтээгдэхүүний нэр	Техникийн үзүүлэлт	Бараа, бүтээгдэхүүнийг хүргэх эцсийн цэг	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нийлүүлэх хугацаа /Гэрээ байгуулсан өдрөөс хойш/

Хүлээн зөвшөөрсөн :

Худалдагчийг Төлөөлж:

......./......./.....

Худалдан авагчийг төлөөлж:

......./......./.....

Худалдах, худалдан авах гэрээний

Хавсралт 3

**Бараа бүтээгдэхүүний нэгжийн болон нийт үнэ**

Нэр төрөл	Барааны бүтээгдэхүүний тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн нийт үнэ	НӨАТ	Нийт үнэ /6+7/
1	2	3	4	5	6	7	8
Нийт үнэ							

Тайлбар: Гэрээний дагуу нийлүүлэх бараа, бүтээгдэхүүний нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тодорхой тусгана.

Гэрээний нийт үнэд- Худалдагчийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу төлөх ёстой бүх татвар, хураамж түүнчлэн бараа бүтээгдэхүүнийг Худалдан авагчийн техникийн тодорхойлолтод тухайлан заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад бүх зардал шингэсэн болно.

Хүлээн зөвшөөрсөн :

Худалдагчийг Төлөөлж:

......./...../

Худалдан авагчийг төлөөлж:

......./...../